ДУАГ

ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

# Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан ҮАГ-ГАГ/2017/02-ГА








*Орон нутгийн хөрөнгө оруулалт үр ашиг муутай байна.*

Мандалговь хот
2017 он

Тайланг бэлтгэсэн:

Дундговь аймгийн Аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг

Аудитын менежер Х.Наранцацрал

Ахлах шинжээч Ч.Бэрхсайхан

Шинжээч Д.Должинсүрэн

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот

2017 оны 4 дүгээр сар


| | |
|---|---|
| Товчилсон үгс | 3 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй | 4-6 |
| ***Бүлэг 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэж, үр дүнтэй хэрэгжсэн байна.*** | |
| *А ТАХ нь аймаг, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, салбарын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлоготой уялдсан байна.* | 6-7 |
| *Б ТАХ-ны худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.* | 7-10 |
| *В Хөрөнгө оруулалт ТАХ нь үр дүнтэй хэрэгжсэн боловч яамнаас хуваарилсан хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.* | 10-13 |
| ***Бүлэг 2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ үр ашиг муутай байна.*** | |
| *А Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаагүй байна.* | 13-14 |
| *Б Зарим ТАХ-ний худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгосон* | 14-18 |
| *В Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ гэрээний дагуу хэрэгжсэн боловч үр ашиг муутай байна.* | 18-19 |
| Дүгнэлт | 20 |
| Дээд шатны байгууллагад хүргэх санал | 20 |
| Зөвлөмж | 21 |
| Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал тайлбар | 22 |
| Аудитын газрын тайлбар | 23 |
| Тайлан баталгаажуулсан тушаал | 24-27 |
| Тайлангийн хавсралтууд | 28-36 |

## ТОВЧИЛСОН ҮГС

| | |
|---|---|
| МУ | Монгол Улс |
| УИХ | Улсын Их Хурал |
| ЗГ | Засгийн газар |
| ЭМСЯ | Эрүүл мэнд, спортын яам |
| ХЗС | Хууль зүйн сайд |
| БСШУСС | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд |
| БХБС | Барилга хот байгуулалтын сайд |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ЦЕГ | Цагдаагийн ерөнхий газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| АЗДТГ | Аймгийн Засаг даргын Тамгын газар |
| БСУГ | Боловсрол соёл, урлагийн газар |
| ГХБХБГ | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар |
| ХААА | Худалдан авах ажиллагааны алба |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| МХГ | Мэргэжлийн хяналтын газар |
| МСҮТ | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв |
| ТХДЖТ | Төв халхын дуулалт жүжгийн театр |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| ТАХ | Төсөл, арга хэмжээ |
| ХАА | Худалдан авах ажиллагаа |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ОНХО | Орон нутгийн хөрөнгө оруулалт |
| ОУБ | Олон улсын байгууллага |

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:** Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаал, Дундговь аймгийн Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

**Аудитын зорилт:** Дундговь аймагт 2016 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж дүнг холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүн, үр ашигтай хэрэгжсэн эсэх,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүн, үр ашигтай хэрэгжсэн эсэх.

**Àóäèòàà àø èãëàñàí øàëãóóð ¿ç¿¿ëýëò:** Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Òºðèéí áîëîí îðîí íóòãèéí º ì ÷èéí хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд;
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”;
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Засгийн газрын 2015 оны 377 дугаар тогтоол;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

**Аудитын хамрах хүрээ:** Аудитад Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагуудад хэрэгжүүлсэн улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулав.

Эрх шилжиж ирээгүй төсөл, арга хэмжээний хувьд ашиглалтын нөхцөл байдлыг тухайн обьект дээр очиж, фото зураг авалтаар баримтжуулан, бүртгэл тайланд тусгасан эсэхийг үндсэн хөрөнгийн тодруулга тайлантай тулган шалгасан.

Эрх шилжиж ирсэн барилгын засварын ажлыг зураг төслийн дагуу хийгдсэн эсэхийг тулган шалгаж, гүйцэтгэлд хэмжилт хийн баримтжууллаа.

**Аудитын арга зүй:** Аудитыг төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүй, тулгуур зарчим (АДБОУС 300), гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглан, журам, батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв. Аудитын арга зүйн дагуу холбогдох байгууллагын албан

тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, худалдан авалт, хөрөнгө оруулалт болон санхүүгийн баримт материалыг түүвэрчлэн шалгах, мэдээ тайланг гаргуулж тулган баталгаажуулах, зэрэгцүүлэх, харьцуулах, ажиглалт хийх, бодит байдлыг фото зураг авч баримтжуулах зэрэг шаардлагатай горимуудыг хэрэгжүүлэн, цуглуулсан нотлох баримтад харьцуулалт, судалгаа, шинжилгээ хийж дүнг нэгтгэн боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж өглөө.

**Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:** Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн аудитын багийн ахлах шинжээч Ч.Бэрхсайхан, шинжээч Д.Должинсүрэн нар 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэлээ.

## Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дундговь аймагт 31,974.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ТАХ-нд 12,252.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлсан байна. Үүнээс 2,952.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ эрх шилжин ирсэн, 29,021.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ эрх шилжин ирээгүй байна.

Эрх шилжин ирсэн нийт ТАХ-ний 2,440.6 сая төгрөг буюу 82.7 хувь нь барилга угсралтын ажил, 461.9 сая төгрөг буюу 15.6 хувь нь барилгын засварын ажил, 25.8 сая төгрөг буюу 1.7 хувь нь тоног төхөөрөмж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-г аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 03-ны 10 дугаар тогтоолоор 500.0 сая төгрөгөөр баталсныг 2016 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор 193.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 693.5 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 567.7 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

*Бүлэг 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэж, үр дүнтэй хэрэгжсэн байна.*

*1.А ТАХ нь аймаг, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, салбарын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлоготой уялдсан байна.*

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын ТАХ-үүдээс ТЕЗ-ийн шийдвэрээр аймагт эрх шилжин ирсэн 540.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ тайлант онд шинээр хэрэгжсэн, 2,412.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ он дамжин хэрэгжсэн байна. Эрх шилжин ирээгүй ТАХ-ний хувьд бүгд он дамжин хэрэгжсэн.

Тайлант онд шинээр хэрэгжсэн дараах 3-н засварын ажил нь аймаг, сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын бодлоготой уялдсан байна.

Хүснэгт-1

| Д/д | Төсөл арга хэмжээний нэр | Нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тусгагдсан эсэх | Салбарын хөрөнгө оруулалтын бодлогод тусгагдсан эсэх |
|---|---|---|---|
| 1 | Сайнцагаан сумын 4-р цэцэрлэгийн барилгын засварын ажил | | БСУГ-ын хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтөнд тусгагдсан. |
| 2 | Адаацаг сумын сургуулийн засварын ажил | Адаацаг сумын нийгэм эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан. | |
| 3 | Хулд сумын цэцэрлэгийн засварын ажил | | БСУГ-ын хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтөнд тусгагдсан. |

*Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хуулийн шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн байна.*

ТАХ-ний төлөвлөлтийг эрх шилжин ирсэн, тайлант онд шинээр хэрэгжсэн 3 засварын ажлын хувьд авч үзлээ. Эдгээр засварын ажлууд нь Төсвийн тухай хуулийн 29.4[1], Барилгын тухай хуулийн 32.1.11[2]-д заасны дагуу зураг төсөл боловсруулагдсан төсөл арга хэмжээг төсөвт тусган хэрэгжүүлсэн байна. /Хүснэгт 2/

[1] 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.
[2] 32.1.11. Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх;

Хүснэгт-2

| Д/д | Барилга байгууламж | Зураг төсөв зохиосон огноо | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Сайнцагаан, 4-р цэцэрлэг/ | 2015 | Төсөв батлахаас өмнө зураг төслийг боловсруулсан |
| 2 | Сургуулийн барилгын засвар /Дундговь, Адаацаг/ | 2015 | Төсөв батлахаас өмнө зураг төслийг боловсруулсан |
| 3 | Цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Хулд/ | 2015 | Төсөв батлахаас өмнө зураг төслийг боловсруулсан |

*1.Б Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.*

*Худалдан авах ажиллагааны аргыг хуулийн дагуу сонгон, үнэлгээний хороог журмын дагуу зохион байгуулсан байна.*

Дундговь аймгийн 2016 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих эрх шилжиж ирсэн 5 ТАХ, улсын төсвийн байгууллагын захиалгаар ирсэн 2 ТАХ, нийт 7 ТАХ-нд тендер шалгаруулалт зохион байгуулахаар батлагдсан байна.

Тайлант онд зохион байгуулсан тендер шалгаруулалтыг ЗГ-ын 2013 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 68 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийг үндэслэн 5 ТАХ-г харьцуулалтын аргаар, 2 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулжээ. (Хүснэгт-3)

Үүнээс АЗДТГ-ын албан хэрэгцээнд нийлүүлэх тоног төхөөрөмжийн ажил, Луус суманд цагдаагийн кобан барих ажлын тендер шалгаруулалт амжилтгүй болж шууд гэрээ, бусад тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдаж хамгийн сайн үнэлэгдсэн тендерт оролцогчтой гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 3 /Сая төгрөгөөр/

| Д/д | 2016 онд эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний нэр | Төсөвт өртөг | Гэрээний дүн | Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам | Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам | Эрх шилжиж ирсэн шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Адаацаг сумын сургуулийн байр, спорт заалны засвар | 130.0 | 124.4 | Нээлттэй | Нээлттэй | БСШУЯ-аас |
| 2 | Сайнцагаан сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгын засвар | 120.0 | 104.9 | Нээлттэй | Нээлттэй | БСШУЯ-аас |
| 3 | Хулд сумын Цэцэрлэгийн барилгын засвар | 80.0 | 72.4 | Харьцуулалт | Харьцуулалт | БСШУЯ-аас |
| 4 | Тоног төхөөрөмж /АЗДТГ/-т | 50.0 | 49.9 | Харьцуулалт | Харьцуулалт | ЗГХЭГ-аас |
| 5 | Цагаандэлгэр сумын цэцэрлэгийн дээврийн засвар | 80.0 | | Харьцуулалт | Харьцуулалт | БСШУЯ-аас |
| 6 | Луус суманд цагдаагийн кобан барих ажил | 80.0 | 80.0 | Харьцуулалт | Харьцуулалт | Аймгийн Цагдаагийн газраас |
| 7 | Гурвансайхан суманд | 80.0 | 79.4 | Харьцуулалт | Харьцуулалт | Аймгийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | цагдаагийн кобан барих ажил | | | | | Цагдаагийн газраас |
| | **Нийт дүн** | **620.0** | **511.0** | | | |

Үнэлгээний хорооны гишүүдийг аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.4[3]-д заасны дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагаа явуулах бэлтгэл бүрэн хангагдсан байна. /Хавсралт 1/

Нээлттэй зарласан 2 тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлсэн, харьцуулалтын аргаар зарласан 5 тендерийн хувьд хуулинд зааснаар 3-аас доошгүй этгээдэд үнийн санал ирүүлэх урилга хүргүүлжээ.

Энэ нь тендерт оролцогчдыг эрх тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэн, ил тод байдлыг ханган ажилласан байна. /Хавсралт 2/

*Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны журмыг баримталсан байна.*

2016 онд эрх шилжиж ирсэн 540.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ-ний тендер шалгаруулалтанд 30 оролцогч материалаа ирүүлснээс тендерийн баримт бичигт тавьсан шаардлагыг хангаагүй 16 оролцогчийн тендерээс татгалзсан байна.

Шалгуур хангасан тендерүүдээс үнийн саналаар эрэмбэлэн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерт оролцогчтой гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсэн байна.

Иймд Худалдан авах ажиллагааны алба нь худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулан ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49.2[4]-д заасан шаардлагыг бүрэн хангасан байна.

*Хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж тайлагнасан байна.*

[3] 47.4-д /Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна./

[4] 49.2.Тендерийн хавтаст хэрэг дараахь баримт бичиг, материалаас бүрдэнэ: Үүнд: 49.2.1.худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, шаардлагатай бол тайлбар; 49.2.2.нээлттэй тендер шалгаруулалтаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгосон үндэслэл; 49.2.3.худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай товч тодорхойлолт, тендерийн баримт бичиг; 49.2.4.захиалагч, тендерт оролцогчтой харилцсан албан бичиг; 49.2.5.тендерт оролцогчдын ирүүлсэн тендер; 49.2.6.тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж; 49.2.7. тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл; 49.2.8. гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр, гэрээ; 49.2.9. тухайн тендер шалгаруулалттай холбоотой бусад баримт бичиг; 49.2.10. гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг.

Аудитаар тендерийн урилга нийтэлж эхэлснээс тендер шалгаруулах хүртэлх хугацааг хууль, журамд нийцсэн эсэхийг судалж үзэхэд тендер хүлээн авах хугацаа 7-31 хоног, шалгаруулах хугацаа 23-60 хоног буюу нийт 30-91 хоногт багтаан зохион байгуулжээ.[5] /Хүснэгт 4/

Хүснэгт-4

| Д/д | Захиалагчийн нэр | Урилга нийтэлсэн огноо | Үнийн санал ирүүлэх хугацаа | Үнийн санал ирүүлэх хоног | Тендер нээсэн огноо | Тендер шалгаруулал сан огноо | Шалгару улсан хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сургуулийн байр, спорт заалны засвар /Дундговь, Адаацаг/ | 2016.04.08 | 2016.05.09 | 31 | 2016.05.09 | 2016.07.07 | 60 |
| 2 | 4-р цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Сайнцагаан/ | 2016.04.06 | 2016.05.06 | 30 | 2016.05.06 | 2016.06.02 | 26 |
| 3 | Цэцэрлэгийн засвар /Дундговь, Хулд/ | 2016.04.05 | 2016.04.13 | 8 | 2016.04.13 | 2016.05.05 | 23 |
| 4 | Аймгийн ЗДТГ-т тоног төхөөрөмж | 2016.05.25 | 2016.06.02 | 8 | 2016.06.02 | 2016.07.19 | 48 |
| 5 | Гурвансайхан сумын цагдаагийн кобан барих ажил | 2016.03.04 | 2016.03.11 | 7 | 2016.03.11 | 2016.04.20 | 41 |
| 6 | Луус сумын цагдаагийн кобан барих ажил | 2016.03.04 | 2016.03.14 | 10 | 2016.03.14 | 2016.04.26 | 44 |

Судалгаанаас харахад Адаацаг сумын сургуулийн засварын ажил, аймгийн ЗДТГ-т тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын тендер шалгаруулалтад 45-аас дээш хоног зарцуулсан нь тендер шалгаруулах явцад оролцогч талуудаас гомдол гарч Сангийн яамнаас хугацааг 30 хоногоор сунгасантай холбоотой байна.

Худалдан авах үйл ажиллагааг хуульд[6] заасан хугацаанд зохион байгуулсан байна. (Хавсралт 4)

Луус сумын цагдаагийн кобан барих ажлын тендер шалгаруулалтанд 3 оролцогч үнийн санал ирүүлсэн боловч ТБОНӨХБАҮХАТХ-ын 27.1[7]-д заасан

[6] ТБОНӨХБАҮХА хуулинд заасны дагуу

- Тендерийн урилгад нээлттэй тендер хүлээн авах эцсийн хугацааг хуулинд заасны дагуу 30 буюу түүнээс дээш хоногоор, харьцуулалтын аргын үед урилга илгээсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтооно.
- Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг тендерийн хүчинтэй хугацаа буюу 45 хоногт багтаан зохион байгуулах ёстой гэж заасан.

[7] 27.1.Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараахь шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ:
27.1.1.энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхийн шаардлага;
27.1.2.техникийн тодорхойлолт;
27.1.3.тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага.

шаардлагыг хангаагүй тул бүх тендерээс татгалзаж шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргэгдсэн.

''Шувуутай хийморь'' ХХК анх 77.9 сая төгрөгийн тендерийн үнийн санал ирүүлсэн боловч санхүүгийн тайланг нотариатаар баталгаажуулаагүй шалтгаанаар тендерээс хасагдсан. Гэтэл захиалагч ''Шувуутай хийморь'' ХХК-тай ТАХ-ны төсөвт өртгөөр буюу 80.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулжээ. Шууд гэрээг ''Шувуутай хийморь'' ХХК-ний анх ирүүлсэн үнийн саналаар байгуулсан бол тендерээс 2.1 сая төгрөг хэмнэх боломжтой байжээ. /Хүснэгт 5/

Хүснэгт 5 /Сая төгрөгөөр/

| Тендерт оролцогч Компани нэр | Гэрээний дүн | Санал болгосон үнэ | Хэмнэж болох байсан төсөв | Татгалзсан шалтгаан |
|---|---|---|---|---|
| **Зой тройзон ХХК** | 80.0 | 77.9 | 2.1 | Шүүхийн тодорхойлолт байхгүй |
| **Шувуутай хийморь ХХК** | 80.0 | 77.9 | 2.1 | Санхүүгийн тайланг нотариатаар баталгаажуулаагүй |
| **Дөл БГМ ХХК** | 80.0 | 79.5 | 0.5 | Татварт өртэй |

Иймд тендер амжилтгүй болж шууд гэрээ байгуулах үед тендерт оролцогчдын тендерээс хасагдсан шалтгааныг судлан, тендерийн үнэ, чанарт нөлөөлөх алдаа биш хайхрамжгүй байдлаас болсон алдаа байсан эсэхийг тодруулж тухайн оролцогчийн тендерт ирүүлсэн үнийн саналаар гэрээ байгуулж, худалдан авах ажиллагааны хэмнэлт бий болгох боломжийг судлах шаардлагатай байна.

*1.В Хөрөнгө оруулалтын ТАХ нь үр нөлөөтэй хэрэгжсэн боловч яамдаас хуваарилсан хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.*

***В.1 Зарим ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй байна.***

Аудитаар эрх шилжин ирсэн 6-н төсөл арга хэмжээний хувьд гэрээний гүйцэтгэлийг үзэхэд хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний гэрээнд заагдсан хугацаанд хүлээж аваагүй, зарим ажил дутуу хийгдсэн байна. /Хүснэгт 6/

Хүснэгт-6

| Д/д | Төсөл арга хэмжээний нэр | Гэрээнд заасан хугацаа | | | Хүлээн авсан огноо | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| | | Эхлэх | Дуусах | Сунгасан | | |
| **1** | Хулд сумын цэцэрлэгийн засварын ажил | 5/20/2016 | 6/30/2016 | | 8/3/2016 | Барилгын засварын ажлыг хугацаанд нь гүйцэтгэсэн боловч комисс хожуу хүлээн авсан |
| **2** | Өндөршил сумын ЭМТ-ийн засвар | 4/25/2015 | 6/20/2016 | | 9/5/2016 | Барилгын засварын ажлыг хугацаанд нь гүйцэтгэсэн боловч комисс хожуу хүлээн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авсан |
| **3** | Адаацаг сумын сургуулийн засварын ажил | 7/25/2016 | 9/13/2016 | | 11/24/2016 | Гэрээнд заасан хугацаанд ажлыг гүйцэтгээгүй тул алданги тооцож төлүүлсэн |
| **4** | АЗДТГ Тоног төхөөрөмж | 8/31/2016 | 9/1/2016 | 12/20/2016 | 2015.07.24 | 24.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлээгүй |

АЗДТГ-ын албан хэрэгцээнд 49.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хувьд “ЖМДЖИ” ХХК-иас “Эдийн засгийн төлөвлөөгүй хүчин зүйлийн улмаас тоног төхөөрөмжүүдийг хугацаанд нь нийлүүлж хүлээлгэн өгөх боломжгүй байна” гэсэн хүсэлт ирүүлснийг үндэслэн гэрээг сунгасан байна.

Дээрх ажлаас 24.1 сая төгрөгийн нарны сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийг “Монгол Улсад борлуулдаг төлөөлөгч компанигүй байсан тул Япон улсын хувийн үйлдвэрт захиалснаас нийлүүлэгч тал гэрээний үүргийн дагуу тоног төхөөрөмжөө хугацаанд нь ирүүлээгүй тул уг төхөөрөмжийг нийлүүлэх боломжгүй болсон.” гэсэн шалтгаанаар нийлүүлээгүй байна.

Адаацаг сумын Сургуулийн засварын ажлыг 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдөр эхлүүлж 2016 оны 09 сарын 13-ны өдөр дуусгахаар гэрээ байгуулсан боловч гэрээний хугацаанд ажлыг гүйцэтгээгүй байна.

Гэрээнд заасны дагуу хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувиар алданги тооцож гүйцэтгэгч компаниар төлүүлсэн байна.

Хулд сумын цэцэрлэгийн засвар, Өндөршил сумын ЭМТ-ийн засварын ажлуудыг гүйцэтгэгч компани хугацаанд нь гүйцэтгэсэн боловч комисс хожуу хүлээн авсан байна.

***<u>В.2 Яамнаас хуваарилсан хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.</u>***

БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд нийт 18 сургуульд 6.9 сая төгрөгийн өртөгтэй ухаалаг самбарын иж бүрдлийг хуваарилжээ. /Хүснэгт-7/

Хүснэгт-7 /Сая төгрөгөөр/

| № | Хөрөнгийн нэр | Үнэ |
|---|---|---|
| 1 | Проекторын хөл | 1.1 |
| 2 | Проекторын самбар | 2.3 |
| 3 | Проектор | 3.5 |
| | **Нийт** | 6.9 |

Аудитын явцад хөрөнгийн ашиглалтын явцтай танилцахад тус тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байсан. Энэ нь төхөөрөмжийг хэрхэн ажиллуулах талаар мэдлэг хомс, нийлүүлэгч компани заавар, танилцуулга хийгээгүй, төхөөрөмж нь ашиглалтын шаардлага хангаагүйтэй /проекторын хөл нь самбар, проектороо даахгүй учир хөлийг ашиглах

боломжгүй/ холбоотой байна. Хөрөнгийн ашиглалтыг сайжруулж бүрэн хүчин чадлаар нь ашиглах талаар холбогдох байгууллагуудад зөвлөмж өгч ажиллав.

Тайлант онд БСШУСЯ-аас 6 суманд нийт 53.4 сая төгрөгийн үнэтэй физикийн лабораторийн хэрэглэгдэхүүн нийлүүлсэн. Тус хэрэглэгдэхүүнийг хэрхэн ашиглах талаар нийлүүлэгч компани болон захиалагч талаас сургалт, зааварчилгаа өгөөгүй, анги кабинет хүрэлцээгүй, мөн багш нарын санаачлагагүй байдалтай холбоотойгоор эдгээр хөрөнгийн ашиглалт хангалтгүй, зарим сургуулиуд огт ашиглаагүй байна.

Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай байна.

Тус хэрэглэгдэхүүнүүдийг хичээлийн хөтөлбөртэй хэрхэн уялдуулж яаж ашиглах талаар сумдын сургуулийн багш нарт сургалт зохион байгуулж хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар аймгийн БСУГ-т зөвлөмж хүргүүллээ.

Тайлант онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ТАХ-г нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан боловч Луус сумын сургуульд БСШУСЯ-аас хуваарилсан 6.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн. Тус зөрчлийг арилгуулахаар Луус сумын Сургуулийн захиралд хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

Тайлант онд хэрэгжсэн нийт 7 ТАХ-ээс Хулд сумын цэцэрлэгийн барилгын засвар, Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажлыг хувийн хэрэгт тусгаагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.18[8], 46.1.12[9], 2016 онд мөрдөгдөж байсан Барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 71 дүгээр тушаалаар баталсан “Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын хувийн хэрэг хөтлөх” журмын хавсралт 1-ийн 1.2[10], 1.3[11] дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Уг зөрчлийг арилгуулахаар Хулд сумын Цэцэрлэгийн эрхлэгчид албан шаардлага хүргүүллээ.

Тайлант онд Луус, Гурвансайхан сумдын цагдаагийн кобаныг улсын комисс хүлээн авч, ашиглалтанд оруулсан боловч барилгын ажлын баримт бичгийг архивт шилжүүлээгүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3[12]-д заасныг зөрчсөн байна.

---

[8] 33.1.18-д /Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмыг батлах;/

[9] 46.1.2. /Энэ хуулийн 33.1.18-д заасан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх;/

[10] 1.2-т /"Барилгын тухай" хуулийн 3.1.4-д заасан "барилга байгууламж" гэсэн тодорхойлолтод хамаарагдах Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдсан, бүх төрлийн барилга байгууламжийн /гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын иргэдийн өмчийн болон тэдний мэдлийнхээс бусад/ хувийн хэргийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр заавал хөтөлнө/

[11] 1.3-д /Барилга байгууламжийн хувийн хэрэг нь тухайн барилга байгууламжийн ашиглалтын хугацаанд хийгдсэн өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэл, их засварын ажил, үзлэг шалгалт, гарсан эвдрэл, гэмтэл, согогийн талаарх мэдээлэл, уг барилга байгууламжийн үндсэн үзүүлэлтийг агуулсан баримт бичиг байна./

[12] 46.3-д /Хөрөнгө оруулагч, захиалагч ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын явцад захиалагч, зохиогч, улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын чанар, аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлт, ашиглалтад оруулсан баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш 30 өдөрт багтаан холбогдох архивт шилжүүлнэ./

Өмнөх аудитаар тухайн онд хэрэгжсэн 2 цагдаагийн кобаны баримт бичгийг архивт шилжүүлээгүй зөрчил илэрсэн бөгөөд тус 2 барилгын баримт бичгийг аймгийн архивт шилжүүлэх саналыг ЦЕГ-т уламжлах талаар Засаг даргад зөвлөмж хүргүүлсэн боловч тус зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүй зөрчил дахин давтагдан гарсан байна.

Иймд барилга байгууламжийн баримт бичгийг архивт шилжүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж хүргүүллээ.

*Бүлэг 2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ үр ашиг муутай байна.*

*2.А. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ нь нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаагүй байна.*

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 693.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Эдгээр ТАХ-нээс “Иргэний эрх зүйн боловсрол хөтөлбөр”-өөс бусад ТАХ нь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй байна.

Зарим ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг нарийн тодорхойлоогүй ерөнхий байдлаар төлөвлөжээ.

Тухайлбал 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Зураг төсөв”, 112.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хөтөлбөр, арга хэмжээ” зэрэг хэрэгцээ шаардлагыг нарийн тодорхойлоогүй ерөнхий байдлаар ТАХ-г төлөвлөжээ.

Хүснэгт-8 /Сая төгрөгөөр/

| Д/д | Зураг төсөв хийлгэх ажлын нэр | Олгосон санхүүжилт |
|---|---|---|
| 1 | ЗДТГ-ын өрөө, тасалгаа, хурлын залны дотоод засал | 3.6 |
| 2 | Их газрын Чулууны уулын задгай театрын цогцолборын тохижилт, тэмдэг, тэмдэглэгээний ажил | 7.5 |
| 3 | Эрдэнэдалай сумын цахилгаан дамжуулах шугам сүлжээг сифжүүлэх шинэчлэх ажил | 20.0 |
| **Нийт дүн** | | 31.0 |

“Зураг төсөв” ТАХ-ний хүрээнд 2016 онд хэрэгжсэн болон 2017 онд хэрэгжих 3 ажлын зураг төсөвт 31.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-д */өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох;/* мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-д */Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт*

*нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна./* гэж заасныг тус тус зөрчиж байна.

Шүүхийн шийдвэрээр өмнөх жилүүдэд хийгдсэн ажлын зардлыг санхүүжүүлэхээр 185.5 сая төгрөгийн төсөв баталсан байна. Үүнд:

Нийслэлийн зураг төслийн хүрээлэн ОНӨААТҮГ нь 10 сумын "Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээ"-ний 5 багц ажлын гүйцэтгэгчээр шалгарч, гэрээ байгуулжээ.

Ажлын гүйцэтгэлийн явцад төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын жагсаалтаас хасч, ажлыг зогсоож, санхүүжилтийг олгоогүй.

Үүнд "Нийслэлийн зураг төслийн хүрээлэн" ОНӨААТҮГ нь шүүхэд нэхэмжлэл гаргаж улмаар Дундговь аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шүүхийн шүүгчийн захирамжаар нийт ажлын 30 хувийг гүйцэтгэсэн болохыг тогтоож 169.5 сая төгрөгийг Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газраар төлөөлүүлэхээр шийдвэр гарч орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн байна.

Үлдсэн ажлыг Нийслэлийн зураг төслийн хүрээлэн ОНӨААТҮГ-аар үргэжлүүлэн гүйцэтгүүлэх талаар АЗДТГ-аас чиглэл өгсөн.

Гэтэл дээрх 10 сумдаас Луус, Сайхан-Овоо, Говь-Угтаал сумд өөр компанитай давхар гэрээ байгуулж тодорхой хэмжээний ажил гүйцэтгүүлсэн байна.

Мөн Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар тариалан эрхлэлтийг дэмжих сантай 2010 оны 03 сарын 03-ны өдрийн 113 тоот гэрээгээр 35 морины хүчтэй трактор, төмсний иж бүрдлийн хамт нийт 15.3 сая төгрөгийн зээлийг урьдчилгаа төлбөр болох 4.8 сая төгрөг төлөн үлдэгдэл 70 хувь болох 10.4 сая төгрөгийг 2 жилийн хугацаанд хуваан төлөхөөр санхүүгийн түрээсийн гэрээ байгуулсан боловч төлөөгүй. Үүнд тариалан эрхлэлтийг дэмжих сангаас шүүхэд нэхэмжлэл гаргаснаар Сум дундын 11 дүгээр шүүхийн 2015 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 143 дугаар шийдвэрээр 15.7 сая төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газраас төлүүлэхээр болж үүнийг 2016 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийн хөрөнгөөс олгосон байна.

Иймд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө аймаг, сумдын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хөгжлийн бодлоготой уялдуулж, хэрэгцээ шаардлагыг нарийн тодорхойлж байх шаардлагатай байна.

### *2.Б Зарим ТАХ-ний худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгосон*

*Үнэлгээний хороог журмын дагуу зохион байгуулсан ч худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгоогүй, ил тод шуурхай байдлыг хангаагүй байна.*

График-1




Дундговь аймгийн 2016 оны ОНХО-аар бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд ТАХ-ний худалдан авах ажиллагааны журмыг сонгохдоо босго үнийг үндэслэн 4 ТАХ-г нээлттэй тендерээр, 6 ТАХ-г харьцуулалтын аргаар, 1 ТАХ-г шууд гэрээ байгуулахаар баталсан боловч гүйцэтгэлээр нээлттэй тендер зарлаагүй, 4 ТАХ-г харьцуулалтын аргаар, 5 ТАХ-г шууд гэрээ байгуулж, 2 ТАХ-г шүүхийн шийдвэрийг үндэслэн санхүүжүүлсэн байна. ("Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд трактор нийлүүлэх ажил", "Сумдын ерөнхий төлөвлөгөө хийх ажил") (Хавсралт-3),

*<u>Тендер шалгаруулалт зохион байгуулаагүй ТАХ-үүдийн талаар</u>*

- Нээлттэй тендер зарлахаар батлагдсан аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин худалдан авах 140.0 сая төгрөгийн ТАХ-г 4 багц болгон хувааж 70 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 автомашиныг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, бусад 3 автомашиныг харьцуулалтын аргыг ашигласан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ын 8.5-д /*Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно./* мөн хуулийн 8.7.1-д /тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох;/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.
- Мөн 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Зураг төсөв" ТАХ-г аймгийн "ЗДТГ-ын хурлын зал, өрөө тасалгааны засварын ажлын зураг төсөв" боловсруулах, "Их газрын чулууны задгай театрын цогцолборын тохижилт, тэмдэг тэмдэглэгээний ажлын зураг төсөв" боловсруулах "Эрдэнэдалай сумын төвийн цахилгаан дамжуулах шугам сүлжээг сифжүүлэх шинэчлэх" ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил гэсэн 3 багц арга хэмжээ болгон хувааж нээлттэй тендер зарлалгүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2-д /Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ./ мөн хуулийн 8.5-д /*Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно./* мөн хуулийн 8.7.1-д /тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох;/ гэж заасныг тус тус зөрчсөн.

*Дээрх худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлүүдэд* ТБОНӨХБАҮХАТХ-*д заасан хариуцлага тооцуулах саналыг Сангийн яаманд хүргүүлэхээр Үндэсний аудитын газарт уламжиллаа.*

Эрдэнэдалай сумын Сургууль, Сайнцагаан сумын 2-р сургуулийн ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийн ажлын хувьд Мобиком болон Дэлхийн зөн ОУБ-ууд хамтран хэрэгжүүлэх гурвалсан гэрээ байгуулсан. Тендер шалгаруулалтыг Мобиком корпораци, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ууд зохион байгуулж төслийн хэрэгжүүлэгчээр Роял Кинг Констрашн ХХК сонгосон тул 3 талт гэрээнд заасны дагуу төлбөрийг шилжүүлсэн байна.

Тендер шалгаруулалт явуулсан 5 ТАХ-ний 8 ажлын хүрээнд худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулсан эсэхийг авч үзлээ. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын тоног төхөөрөмж, тохижилт
2. Байгаль хамгаалагч нар болон багийн засаг дарга нарын албан хэрэгцээнд мотоцикл
3. Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин /Мазда-6/
4. АЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин /Патриот/
5. Нэгдсэн эмнэлэг /Портер автомашин/
6. Өлзийт сум /Пургон автомашин/
7. АЗДТГ-ын автомашины парк засвар
8. Бүрдийн уянга зуслангийн дотор бие засах газрын засвар тохижилт

Дээрх ТАХ-ний үнэлгээний хорооны гишүүдийг аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.4[13] -д заасны дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагаа явуулах бэлтгэл бүрэн хангагдсан байна.

Аймгийн Засаг даргын 2016 оны 3 сарын 11-ний өдрийн А/95 дугаар захирамжаар Өлзийт сумын автомашин нийлүүлэх ажлын тендер зохион байгуулах эрхийг Өлзийт сумын Засаг даргад шилжүүлж, үнэлгээний хороог хуулийн дагуу байгуулсан байна.

*Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны журмыг баримталсан байна.*

2016 онд ОНХО-аар шинээр хэрэгжсэн 266.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ-ний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна. Нэгдсэн эмнэлгийн автомашин, АЗДТГ-ын автомашины парк засварын ТАХ-нд тендерийн санал ирээгүй байна.

Бусад 6 ТАХ-нд 9 оролцогч тендер ирүүлснээс тендерийн баримт бичигт заасан шаардлагуудыг хангаагүй 6 оролцогч хасагдаж, 3 тендер амжилттай болж гэрээ байгуулах эрх олгогдсон, 5 тендер амжилтгүй болж шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргэгдсэн байна.

[13] 47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

Аудитаар амжилттай шалгарсан 3 тендерт оролцогчдын материалыг тендерийн баримт бичигт тусгасан шаардлагуудын дагуу дахин үнэлж үзэхэд шалгуур хангасан баримтуудаас үнийн саналаар эрэмбэлэн хамгийн бага үнийн санал ирүүлсэн оролцогчийг шалгаруулсан байна.

*Хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.*

Аудитаар тендерийн урилга нийтэлж эхэлснээс тендер шалгаруулах хүртэлх хугацааг ТБОНӨХБАҮХАТХ[14]-д нийцсэн эсэхийг судалж үзлээ.

Хүснэгт-9

| Д/д | Захиалагчийн нэр | Урилга нийтэлсэн огноо | Үнийн санал ирүүлэх хугацаа | Үнийн санал ирүүлэх хоног | Тендер нээсэн огноо | Тендер шалгаруулалсан огноо | Шалгарулсан хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | Аймгийн ИТХ-ын тоног төхөөрөмж, тохижилт | 2016.05.24 | 2016.05.31 | 5 | 2016.05.31 | 2016.07.06 | 36 |
| **2** | Байгаль хамгаалагч нар, багийн ЗД нарын албан хэрэгцээнд мотоцикл | 2016.02.24 | 2016.03.02 | 6 | 2016.03.02 | 2016.03.11 | 10 |
| **3** | Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин | 2016.10.10 | 2016.11.10 | 30 | 2016.11.10 | 2016.11.14 | 4 |
| **4** | АЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин | 2016.05.03 | 2016.05.10 | 6 | 2016.05.10 | 2016.05.30 | 20 |
| **5** | Нэгдсэн эмнэлэг /автомашин/ | 2016.05.03 | 2016.05.10 | 6 | 2016.05.10 | 2016.05.30 | 20 |
| **6** | Өлзийт сум /автомашин/ | 2016.05.05 | 2016.05.11 | 5 | 2016.05.11 | 2016.05.12 | 2 |
| **7** | АЗДТГ-ын автомашины парк засвар | 2016.11.03 | 2016.11.10 | 6 | 2016.11.10 | 2016.11.10 | 1 |
| **8** | Бүрдийн уянга зуслангийн дотор бие засах газрын засвар тохижилт | 2016.05.18 | 2016.05.25 | 6 | 2016.05.25 | 2016.06.15 | 22 |

[14] -Харьцуулалтын аргын үед тендер хүлээн авах эцсийн хугацааг урилга илгээсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтооно.
-Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг тендерийн хүчинтэй хугацаа буюу 45 хоногт багтаан зохион байгуулах ёстой.

Судалгаанаас харахад тендер хүлээн авах хугацаа 5-30 хоног, шалгаруулах хугацаа 1-22 хоног буюу нийт 6-52 хоногт багтаан тендер шалгаруулалтыг хууль, журмын хүрээнд зохион байгуулсан.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаанаас нийт 1.3 сая төгрөгийн төсвийн хэмнэлт хийсэн байна.

Хүснэгт-10 /Сая төгрөгөөр/

| № | Орон нутгийн хөрөнгө оруулалт | Төсөвт өртөг | Олгосон санхүүжилт | Үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| 1 | Аймгийн ИТХ-ын тоног төхөөрөмж, тохижилт | 20.0 | 20.0 | 0.01 |
| 2 | АЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин | 39.0 | 37.8 | 1.2 |
| 3 | Өлзийт сум /автомашин/ | 23.0 | 22.9 | 0.1 |
| | **Тоног төхөөрөмж** | **266.4** | **265.1** | **1.3** |

Тендер нь амжилтгүй болж шууд гэрээ байгуулсан 5 ТАХ-ний хувьд нийт төсөвт өртгөөр гэрээ байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2016 оны 03 сарын 11 өдрийн А/96 дугаар захирамжаар Өлзийт сумын Засаг даргад машин худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлж, тендерийн хүчинтэй хугацаанд тендер шалгаруулалтыг явуулсан.

*2.В Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ гэрээний дагуу хэрэгжсэн боловч үр ашиг муутай байна.*

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 693.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ баталж гүйцэтгэлээр 567.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнийг зардлын ангиллаар харуулбал:

График 2 /Сая төгрөгөөр/




Орон нутгийн хөрөнгө оруулалтын нийт санхүүжилтийн 233.1 сая төгрөг буюу 41.1 хувийг автомашин, мотоцикл худалдан авахад, 128.6 сая төгрөг буюу 22.7 хувийг барилгын засвар, зураг төсвийн ажилд, 28.5 сая төгрөг буюу 5.0 хувийг тоног төхөөрөмж худалдан авахад, 169.5 сая төгрөг буюу 29.9 хувийг сумдын ерөнхий төлөвлөгөө хийхэд, 8.0 сая төгрөг буюу 1.4 хувийг бусад төсөл арга хэмжээнд зарцуулсан байна.

АЗДТГ-ын албан хэрэгцээнд 70.0 сая төгрөгийн мазда-6 автомашин худалдан авсан.

Эдийн засгийн хямралтай, улс даяар хэмнэлтийн горимд шилжсэн цаг үед төсвийн хөрөнгөөр өндөр үнэтэй автомашин худалдан авсан нь Монгол Улсын Их Хурлын 2016 оны 09 сарын 09 өдрийн 47 дугаар тогтоолын 2.В.6-д /*төсвийн хөрөнгөөр автомашин шинээр худалдан авахгүй байх;*/ 2.В.7-д /*эмнэлгийн түргэн тусламж, онцгой байдал, авлигатай тэмцэх, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, прокурор, цагдаагийн эргүүл хамгаалалт, шүүхийн шинжилгээний алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, хил хамгаалах, батлан хамгаалах салбарын байгууллагаас бусад бүх шатны төсвийн байгууллага албан ажлын хэрэгцээнд нэгээс илүү автомашин хэрэглэхийг зогсоож, тээвэр, шатахуун, сэлбэг хэрэгсэл, үйлчилгээний бусад зардлыг бууруулах;*/ заасантай нийцэхгүй байна.

Иймд цаашид орон нутагт төсвийн хэмнэлтийн горимд шилжин, УИХ, ЗГ-ын тогтоол, Сангийн сайдын тушаалыг хэрэгжүүлж ажиллах талаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн ТАХ-нүүд нь гэрээнд заагдсан хугацаанд багтаж хэрэгжсэн байна. /Хавсралт-5/

Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-нүүдээс дараах ажлуудад барилга, байгууламжийн хувийн хэрэг хөтлөөгүй зөрчил илэрлээ. Үүнд:

- Эрдэнэдалай сумын Сургуулийн ариун цэврийн эрүүл ахуйн байгууламж,
- Сайнцагаан сумын Сургуулийн ариун цэврийн эрүүл ахуйн байгууламж

Дээрхи байгууламжуудад хувийн хэрэг нээж хөтлүүлэхээр холбогдох албан тушаалтнуудад хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. ¯¿í ä:

*Улсын төсвийн хөрөнгө оруулалт*

1. ТАХ нь аймаг, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, салбарын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлоготой уялдсан байна.
2. ТАХ-ны худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.
3. Хөрөнгө оруулалт ТАХ нь үр дүнтэй хэрэгжсэн боловч яамнаас хуваарилсан хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.

*Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт*

1. ТАХ нь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй байна.
2. Зарим ТАХ-ний худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгожээ.
3. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ нь үр ашиг муутай байна

## ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГЭХ САНАЛ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Нээлттэй тендер шалгаруулалтын журам хэрэглэх худалдан авах ажиллагаанд гэрээ шууд байгуулах аргыг сонгосон “Зураг төсөв”-ийн ажил, мөн төсөвт өртгийг 4 багц арга хэмжээ болгон хувааж 3 багц арга хэмжээнд багцын нийлбэр өртгийг үндэслэлгүй тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргыг хэрэглэсэн “Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх” ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулсан холбогдох албан тушаалтнуудад ТБОНӨХБАҮХАТХ-ийн 57 дугаар зүйлийн 57.1.1[15], Төсвийн тухай хуулийн 70.3[16]-д заасан хариуцлага тооцуулах саналыг Сангийн яаманд хүргүүлэхээр Үндэсний аудитын газарт уламжилж байна.

[15] 57.1.1 нээлттэй тендер шалгаруулалтын журам хэрэглэх худалдан авах ажиллагаанд уг журмыг хэрэглээгүй бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавaас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;
[16] 70.3-д Энэ хуулийн 6 дугаар зүйл, 24.4-т заасныг зөрчсөн тохиолдолд эрх бүхий этгээд буруутай албан тушаалтанд төрийн албанд 10 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэл ногдуулна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

***Аймгийн Засаг дарга-д:***

1. Гурвансайхан, Луус сумдын цагдаагийн кобаны барилгын баримт бичгийг аймгийн архивт шилжүүлэх ажлыг зохион байгуулах.
2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө аймаг, сумдын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хөгжлийн бодлоготой уялдуулж байх.
3. Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөн, УИХ, ЗГ-ын тогтоол, Сангийн сайдын тушаалыг хэрэгжүүлж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах.

***БСУГ-д:***

1. БСШУСЯ-аас хуваарилсан ухаалаг самбар, физикийн лабораторын хэрэглэгдэхүүнүүдийг хэрхэн ашиглах талаар сумдын сургуулийн багш нарт сургалт зохион байгуулж хөрөнгийн ашиглалтыг сайжруулах.

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ Ч.БЭРХСАЙХАН

ШИНЖЭЭЧ Д.ДОЛЖИНСҮРЭН

## ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төрийн аóäèòûí òóõàé õóóëèéí 19 дүгээр зүйлийн 19.3.1-ò çààñí û äàãóó àóäèòûí òàéëàí ãèéí òº ñëèéã аймгийн Засаг даргад òàí èëöóóëæ, ñàí àë òàéëáàðû ã авлаа.

| | |
|---|---|
| Тайлбар 1-ийг үзнэ үү. | ДУНДГОВЬ АЙМГИЙН<br>ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР<br>48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг,<br>Утас: 7059-2494, Факс: 7059-2896,<br>E-mail: info@dundgovi.gov.mn<br>2017.04.17 № 4/410<br>танай ____-ны № ____-т<br><br>ДУНДГОВЬ АЙМГИЙН<br>АУДИТЫН ГАЗАРТ<br><br>Улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.<br>"ЗДТГ-ын хурлын зал, өрөө, тасалгааны засварын ажлын зураг, төсөв" боловсруулах ажлыг тендер зарлалгүй ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2-т заасныг зөрчиж гүйцэтгүүлсэн байна гэжээ.<br>Уг ажлыг нийт 5,990,600 төсөвт өртөгтэйгээр гэрээлж хийлгэсэн. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.1.1-д заасан босго үнээс дээш гараагүй болно.<br>Өгсөн зөвлөмжийг цаашид үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжүүлж ажиллах болно.<br><br>И. Эрхсайхан<br><br>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН<br>БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН<br>ХЭЛТСИЙН ДАРГА Н.ЭРДЭНЭ-ОЧИР<br>ТУС0068 & 9033548<br>V/18 |

## *АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР*

Төрийн аóäèòûí òóõàé õóóëèéí 19 дүгээр зүйлийн 19.3.2-ò çààñíû ääãóó тайланд дараах засвар оруулллаа.

| ***Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс ирүүлсэн санал, тайлбарт өгөх Аудитын газрын тайлбар*** | |
|---|---|
| ***Тайлбар 1*** | Энэ талаар Бүлэг 2.Б-д “Мөн 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Зураг төсөв” ТАХ-г аймгийн “ЗДТГ-ын хурлын зал, өрөө тасалгааны засварын ажлын зураг төсөв” боловсруулах, “Их газрын чулууны задгай театрын цогцолборын тохижилт, тэмдэг тэмдэглэгээний ажлын зураг төсөв” боловсруулах “Эрдэнэдалай сумын төвийн цахилгаан дамжуулах шугам сүлжээг сифжүүлэх шинэчлэх” ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил гэсэн 3 багц арга хэмжээ болгон хувааж нээлттэй тендер зарлалгүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2-д */Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ./* мөн хуулийн 8.5-д */Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно./* мөн хуулийн 8.7.1-д */тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох;/* гэж заасныг тус тус зөрчсөн байна.” гэж найруулан бичлээ. |

# ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 4 сарын 20 өдөр Дугаар А/6 Мандалговь

Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаал, Гүйцэтгэлийн аудитын журмын 12 дугаар зүйлийн 12.40, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ҮАГ-ГАГ/2017/02-ГА/-г батлсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт, албан шаардлагыг хавсралтаар батлсугай.

3."Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Боловсрол, соёл, урлагийн газарт тус тус хүргүүлсүгэй.

4. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2017 оны 06 дугаар сарын 20-ны дотор аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/, Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /Ц.Бумангэрэл/-д тус тус зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2016 оны 3 дугаар улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, гүйцэтгэлийн аудитын багийн ахлах шинжээч /Ч.Бэрхсайхан/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ОЮУНЧИМЭГ

D:\office\Tushaal\batalgaajuulakh.docx

0000000020

Дундговь аймгийн Аудитын газрын
тэргүүлэх аудиторын 2017 оны .4... дүгээр сарын
20..- ны өдрийн А/16. дугаар тушаалын хавсралт

## АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

**Аудитын код:** УАГ-ГАГ/2017/02-ГА

**Аудитын нэр:** "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"

сая төгрөгөөр

| N | Акт, албан шаардлагын дугаар | Зөрчлийн товч утга | Зөрчигдсөн хуулийн заалт | Зөрчлийн дүн *мян.төг* | Үүнээс | | | | Үр өгөөжийн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Аудитын явцад барагдуулсан | Акт тавигдсан | Албан шаардлага өгсөн | Зөвлөмжөөр өгсөн | Тоо | Мөнгөн дүн |
| 1 | 03/54 | Барилгад хувийн хэрэг нээгээгүй, их засварын өөрчлөлтийг хувийн хэрэгт хөтлөөгүй. /Эрдэнэдалай сургууль/ | Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 71 дүгээр тушаалаар баталсан "Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын хувийн хэрэг хөтлөх" журмын хавсралт 1-ийн 1.2, 1.3 | 83.5 | | | 83.5 | | 1 | 83.5 |
| 2 | 01/48 | Үндсэн хөрөнгө (сурагчийн ширээ, багшийн ширээ)-ийг бараа материалын дансанд бүртгэсэн зөрчил илэрлээ. /Луус сургууль/ | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д /Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө:/, 4.1.1 /Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт;/, Сангийн сайдын "Эдийн засгийн ангилал батлах тухай" 2014 оны 05 дугаар тушаалын 6-р хавсралт, УСНББОУС-17-ын 13 дугаар зүйл | 6.9 | | | 6.9 | | 1 | 6.9 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 02/50 | Барилгад хувийн хэрэг нээгээгүй, их засварын өөрчлөлтийг хувийн хэрэгт хөтлөөгүй./Хулд цэцэрлэг/ | Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 71 дүгээр тушаалаар баталсан "Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын хувийн хэрэг хөтлөх" журмын хавсралт 1-ийн 1.2, 1.3 | 72.4 | | | 72.4 | | 1 | 72.4 |
| 4 | 04/58 | Барилгад хувийн хэрэг нээгээгүй, их засварын өөрчлөлтийг хувийн хэрэгт хөтлөөгүй./Сайнцагаан 2-р сургууль/ | Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 71 дүгээр тушаалаар баталсан "Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын хувийн хэрэг хөтлөх" журмын хавсралт 1-ийн 1.2, 1.3 | 67.5 | | | 67.5 | | 1 | 67.5 |
| 5 | 05/58 | Барилгад хувийн хэрэг нээгээгүй, их засварын өөрчлөлтийг хувийн хэрэгт хөтлөөгүй./Өндөршил ЭМТ/ | Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 71 дүгээр тушаалаар баталсан "Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын хувийн хэрэг хөтлөх" журмын хавсралт 1-ийн 1.2, 1.3 | 61.9 | | | 61.9 | | 1 | 61.9 |
| 6 | | Гурвансайхан, Луус сумдын цагдаагийн кобаны барилгын баримт бичгийг аймгийн архивт шилжүүлээгүй | Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-д /Хөрөнгө оруулагч, захиалагч ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын явцад захиалагч, зохиогч, улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын чанар, аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлт, ашиглалтад оруулсан баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш 30 өдөрт багтаан холбогдох архивт шилжүүлнэ./ | 159.4 | | | | 159.4 | 1 | 159.4 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө аймаг, сумдын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хөгжлийн бодлоготой уялдуулаагүй, хэрэгцээ шаардлагыг нарийн тодорхойлоогүй | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-д /өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох;/, мөн хуулийн 29.2-д /Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна./ | 566.7 | | | | 566.7 | 1 | 566.7 |
| 8 | | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр автомашин худалдан авсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан | Монгол Улсын Их Хурлын 2016 оны 09 сарын 09 өдрийн 47 дугаар тогтоолын 2.В.6-д /төсвийн хөрөнгөөр автомашин шинээр худалдан авахгүй байх;/ 2.В.7-д /эмнэлгийн түргэн тусламж, онцгой байдал, авлигатай тэмцэх, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, прокурор, цагдаагийн эргүүл хамгаалалт, шүүхийн шинжилгээний алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, хил хамгаалах, батлан хамгаалах салбарын байгууллагаас бусад бүх шатны төсвийн байгууллага албан ажлын хэрэгцээнд нэгээс илүү автомашин хэрэглэхийг зогсоож, тээвэр, шатахуун, сэлбэг хэрэгсэл, үйлчилгээний бусад зардлыг бууруулах;/ | 70.0 | | | | 70.0 | 1 | 70.0 |
| 9 | | БСШУСЯ-аас хуваарилсан ухаалаг самбар, физикийн лабораторын хэрэглэгдэхүүнүүдий ашиглалт хангалтгүй. | Төсвийн тухай хуулийн 6.4.1.-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 10.1.11.-д төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах; | 178.6 | | | | 178.6 | 1 | 178.6 |
| | | | **Дүн** | **1,266.9** | **-** | **-** | **292.2** | **974.7** | **9.0** | **1,266.9** |

**АУДИТЫН ГАЗАР**

## ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Хавсралт №1

### 2016 онд шинээр хэрэгжиж эхэлсэн аймагт эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний үнэлгээний хорооны талаар

| Д/д | Төсөл арга хэмжээний нэр | Үнэлгээний хороо байгуулсан огноо | Үнэлгээний хорооны гишүүдийн тоо | Үнэлгээний хорооны гишүүдийн тоо | Салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл | Хувийн хэвшил | Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас томилсон иргэн | Төрийн бус байгууллагын төлөөлөгч | ЗДТГ-ын ажилтан | Худалдан авах ажиллагааны гэрчилгээтэй |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Аймгийн Луус суманд цагдаагийн кобан барих ажил | 2016.03.03 | А/26 | 5 | 1 | 1 | | | 3 | 5 |
| 2 | Аймгийн Гурвансайхан суманд цагдаагийн кобан барих ажил | 2016.03.03 | А/27 | 5 | 1 | 2 | | | 2 | 4 |
| 3 | Аймгийн Адаацаг сумын сургуулийн байр, спорт заалны засвар | 2016.03.30 | А/40 | 5 | 1 | 2 | | | 2 | 5 |
| 4 | Аймгийн Сайнцагаан сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгын засвар | 2016.03.30 | А/41 | 5 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 5 |
| 5 | Аймгийн Хулд сумын цэцэрлэгийн барилгын засвар | 2016.03.30 | А/42 | 5 | 1 | 2 | | | 2 | 5 |
| 6 | Тоног төхөөрөмж /АЗДТГ/-т | 2016.05.20 | А/79 | 5 | 1 | 2 | | | 2 | 5 |

Хавсралт №2

## Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-ний тендерийн урилгыг мэдээлсэн байдал

| Д/д | 2016 онд эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний нэр | Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам | Мэдээлсэн хэлбэр | Тендерт оролцогчдын тоо | Тендер амжилттай болсон эсэх | Гомдол гарсан эсэх |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | Аймгийн Адаацаг сумын сургуулийн байр, спорт заалны засвар | Нээлттэй | Зууны мэдээ сонин, цахимаар зарласан | 9 | Амжилттай | Тийм |
| **2** | Аймгийн Сайнцагаан сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгын засвар | Нээлттэй | Зууны мэдээ сонин, цахимаар зарласан | 5 | Амжилттай | Үгүй |
| **3** | Аймгийн Хулд сумын цэцэрлэгийн барилгын засвар | Харьцуулалт | 3 байгууллагад урилга явуулсан цахимаар зарласан | 9 | Амжилттай | Үгүй |
| **4** | Тоног төхөөрөмж /АЗДТГ/-т | Харьцуулалт | 3 байгууллагад урилга явуулсан цахимаар зарласан | 3 | Амжилтгүй | Тийм |
| **5** | Аймгийн Луус суманд цагдаагийн кобан барих ажил | Харьцуулалт | 3 байгууллагад урилга явуулсан цахимаар зарласан | 3 | Амжилтгүй | Тийм |
| **6** | Аймгийн Гурвансайхан суманд цагдаагийн кобан барих ажил | Харьцуулалт | 3 байгууллагад урилга явуулсан цахимаар зарласан | 1 | Амжилттай | Үгүй |

Хавсралт №3

## Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааны мэдээлэл

/Сая төгрөг/

| № | Орон нутгийн хөрөнгө оруулалт | Төсөвт өртөг | Олгосон санхүүжилт | Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам | Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам | Тендер шалгаруулалтын дараа |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Эрдэнэдалай сумын сургуулийн ариун цэврийн эрүүл ахуйн байгууламж | 30.0 | 30.0 | Харьцуулалт | Шууд | 3-н талын хамтарсан гэрээ |
| 2 | Сайнцагаан сумын сургуулийн ариун цэврийн эрүүл ахуйн байгууламж | 30.0 | 30.0 | Харьцуулалт | Шууд | 3-н талын хамтарсан гэрээ |
| 3 | Аймгийн ИТХ-ын тоног төхөөрөмж, тохижилт | 20.0 | 20.0 | Харьцуулалт | Харьцуулалт | Шууд |
| 4 | Байгаль хамгаалагч нар болон багийн засаг даргын нарын албан хэрэгцээнд мотоцикл | 40.0 | 40.0 | Харьцуулалт | Харьцуулалт | Шууд |
| 5 | Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин | 140.0 | 70.0 | Нээлттэй | Нээлттэй | Амжилттай |
| | АЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин | | 37.8 | | Харьцуулалт | Амжилттай |
| | Нэгдсэн эмнэлэг /автомашин/ | | 8.0 | | Харьцуулалт | Шууд |
| | Өлзийт сум /автомашин/ | | 22.9 | | Харьцуулалт | Амжилттай |
| 6 | АЗДТГ-ын автомашины парк засвар | 38.8 | 38.8 | Харьцуулалт | Харьцуулалт | Шууд |
| 7 | Зураг төсөв | 90.0 | 31.0 | Нээлттэй | Шууд | Шууд |
| 8 | Сумдын ерөнхий төлөвлөгөө | 169.5 | 169.5 | Нээлттэй | Шүүхийн шийдвэр | Шүүхийн шийдвэр |
| 9 | И-офисс хөтөлбөр | 6.5 | 6.0 | Шууд | Шууд | Шууд |
| 10 | АЗДТГ-ын албан хэрэгцээнд трактор | 16.0 | 15.7 | Харьцуулалт | Шүүхийн шийдвэр | Шүүхийн шийдвэр |
| 11 | Иргэний эрх зүйн боловсрол хөтөлбөр | 112.8 | 2.0 | Нээлттэй | Шууд | Шууд |
| | Сум хөх бүрд цогцолборийн үйлчилгээний төвийн тохижилт | - | 6.0 | | Шууд | Шууд |
| | Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх арга | - | - | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээ | | | | | |
| | ТХДЖТ-ийн дээврийн засвар | - | 4.0 | | Шууд | Шууд |
| | Иргэдэд экологийн боловсрол олгох /өвлийн нарлаг хүлэмж сүм, хөх бүрд/ | - | - | | | |
| | Бүрдийн уянга зуслангийн дотор бие засах газрын засвар тохижилт | - | 27.6 | | Харьцуулалт | Шууд |
| | Хөтөлбөр арга хэмжээ /МХГ-ын лабораторын тоног төхөөрөмж/ | - | 8.5 | | Шууд | Шууд |
| | | 693.5 | 567.7 | | | |

Хавсралт 4

## Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааны мэдээлэл

| Д/д | Захиалагчийн нэр | Эрх олгосон огноо | Гэрээ хийсэн огноо | Ажлын хоног | Тендерийн хүчинтэй хоног /тендер нээснээс хойш/ | Тендер шалгаруулсан хоног | Илүү хоног зарцуулсан эсэх |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сургуулийн байр, спорт заалны засвар /Дундговь, Адаацаг/ | 2016.07.07 | 2016.07.25 | 8 | 75 | 68 | Үгүй |
| 2 | 4-р цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Сайнцагаан/ | 2016.06.02 | 2016.06.10 | 6 | 45 | 32 | Үгүй |
| 3 | Цэцэрлэгийн засвар /Дундговь, Хулд/ | 2016.05.05 | 2016.05.16 | 7 | 45 | 30 | Үгүй |
| 4 | Аймгийн ЗДТГ-т тоног төхөөрөмж | 2016.07.19 | 2016.07.27 | 6 | 75 | 55 | Үгүй |
| 5 | Гурвансайхан сумын цагдаагийн кобан барих ажил | 2016.04.20 | 2016.05.01 | 7 | 45 | 48 | Үгүй |
| 6 | Луус сумын цагдаагийн кобан барих ажил | 2016.04.26 | 2016.05.01 | 4 | 75 | 48 | Үгүй |

Хавсралт №5

## Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд Дундговь аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээ

/Сая төгрөг/

| № | Дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | 2016 онд санхүүжих дүн |
|---|---|---|---|---|---|---|
| Эрх шилжин ирсэн | | | | | | |
| Тайланд онд хэрэгжсэн | | | | | | |
| 1 | XII.1.2.2 | Сайнцагаан сумын 4-р цэцэрлэгийн засварын ажил | 2016 | 2016 | 120.0 | 104.9 |
| 2 | XII.1.2.2 | Адаацаг сумын сургуулийн засварын ажил | 2016 | 2016 | 130.0 | 124.4 |
| 3 | XII.1.2.2 | Хулд сумын цэцэрлэгийн засварын ажил | 2016 | 2016 | 80.0 | 72.4 |
| 4 | IV.3.1 | АЗДТГ Тоног төхөөрөмж | 2016 | 2016 | 50.0 | 25.8 |
| 5 | VIII.2.1.2 | Гурвансайхан сумын цагдаагийн кобан | 2016 | 2016 | 80.0 | 79.4 |
| 6 | VIII.2.1.2 | Луус сумын цагдаагийн кобан | 2016 | 2016 | 80.0 | 77.9 |
| Тайланд онд эрх шилжин ирсэн ТАХ-ний дүн | | | | | 540.0 | 484.8 |
| Он дамжин хэрэгжсэн | | | | | | |
| 1 | XII.1.2.2 | Өндөршил сумын ЭМТ-ийн засвар | 2016 | 2016 | 131.9 | 61.9 |
| 2 | XIV.1.1.5 | МСҮТ-ийн барилга | 2014 | 2015 | 2,280.6 | 569.7 |
| Он дамжин хэрэгжиж байгаа эрх шилжин ирсэн ТАХ-ний дүн | | | | | 2,412.5 | 631.6 |
| Нийт эрх шилжин ирсэн ТА-ний дүн | | | | | 2,952.5 | 1,116.4 |
| Эрх шилжин ирээгүй | | | | | | |
| Он дамжин хэрэгжсэн эрх шилжин ирээгүй төсөл арга хэмжээний дүн | | | | | | |
| 1 | XII.1.1.11 | Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дундговь, Дэлгэрхангай сум/ | 2012 | 2016 | 858.4 | 579.2 |
| 2 | XII.1.1.54 | Сургуулийн барилга, 320 суудал /Дундговь, Гурвансайхан сум/ | 2013 | 2017 | 2,898.5 | 354.4 |
| 3 | XII.1.1.89 | Дэлхийн банкны Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл төсөл /монголын талын хөрөнгө/ /Дундговь, Дэрэн сум/ | 2011 | 2016 | 299.2 | 151.9 |
| 4 | XII.1.1.99 | Сургуулийн барилга, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум/ | 2012 | 2016 | 4,461.0 | 15.5 |
| 5 | XII.1.1.102 | Цэцэрлэгийн барилга,150 ор /Дундговь, Эрдэнэдалай сум/ | 2012 | 2016 | 1,084.7 | 51.6 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | XII.1.1.120 | Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Дундговь, Сайхан-Овоо сум/ | 2012 | 2016 | 650.0 | 44.7 |
| 7 | XII.1.1.136 | Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дундговь, Гурвансайхан сум/ | 2011 | 2016 | 550.0 | 15.3 |
| 8 | XII.1.2.2 | Боловсролын салбарын барилга байгууламжийн өргөтгөл, их засвар /Улсын хэмжээнд/ | 2016 | 2017 | 9,200.0 | 6,867.1 |
| 9 | XIV.1.1.5 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрын барилга, 200 ор /Дундговь, Сайнцагаан сум/ | 2012 | 2016 | 2,281.8 | 570.6 |
| 10 | XIV.1.1.8 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр, дадлагын байр, спорт заал, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум/ | 2012 | 2016 | 6,738.0 | 2,486.2 |
| Нийт эрх шилжин ирээгүй ТАХ-ний дүн | | | | | 29,021.60 | 11,136.50 |
| Нийт ТАХ-ний дүн | | | | | 31,974.10 | 12,252.90 |

Хавсралт №6

## Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-ны гэрээний хэрэгжилт

| Д/д | Төсөл арга хэмжээний нэр | Гэрээнд заасан хугацаа | | | Хүлээн авсан огноо | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| | | Эхлэх | Дуусах | | | |
| 1 | Эрдэнэдалай сумын сургуулийн ариун цэврийн эрүүл ахуйн байгууламж | 07/27/2016 | 9/30/2016 | | 9/16/2016 | |
| 2 | Сайнцагаан сумын сургуулийн ариун цэврийн эрүүл ахуйн байгууламж | 07/27/2016 | 9/30/2016 | | 9/5/2016 | |
| 3 | Аймгийн ИТХ-ын тоног төхөөрөмж, тохижилт | 08/01/2017 | 9/1/2016 | | 8/19/2016 | |
| 4 | Байгаль хамгаалагч нар болон багийн засаг даргын нарын албан хэрэгцээнд мотоцикл | 05/13/2016 | 6/13/2016 | | 5/20/2016 | |
| 5 | Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин | 06/14/2016 | 7/14/2016 | | 6/24/2016 | |
| 6 | АЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин | 11/26/2016 | 12/23/2016 | | 11/24/2016 | |
| 7 | Нэгдсэн эмнэлэг /автомашин/ | 07/07/2016 | 8/7/2016 | | 7/18/2016 | |
| 8 | Өлзийт сум /автомашин/ | 05/26/2016 | 6/26/2016 | | 8/23/2016 | Гүйцэтгэгч компаниас шалтгаалан гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй |
| 9 | АЗДТГ-ын автомашины парк засвар | 11/23/2016 | 12/23/2016 | | 12/2/2016 | |
| 10 | Зураг төсөв | 2015.12.25 | 2016.02.25 | | | |
| | | 2016.04.10 | 2016.05.15 | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2016.12.01 | 2016.12.20 | | | |
| **11** | Сумдын ерөнхий төлөвлөгөө | | | | | Шүүхийн шийдвэрээр төлсөн |
| **12** | АЗДТГ-ын албан хэрэгцээнд трактор | | | | | Шүүхийн шийдвэрээр төлсөн |
| | **Хөтөлбөр арга хэмжээ** | | | | | |
| **13** | Сүм хөх бүрд цогцолборийн үйлчилгээний төвийн тохижилт | 12/06/2016 | 12/24/2016 | | 12/20/2016 | |
| **14** | ТХДЖТ-ийн дээврийн засвар | 06/23/2016 | 7/23/2016 | | 8/22/2016 | Ажлыг хугацаанд нь гүйцэтгэсэн. Комисс хожим хүлээж авсан. |
| **15** | МХГ-ын лабораторын тоног төхөөрөмж | 12/19/2016 | 12/23/2016 | | 12/22/2016 | |